

2024

**“МЦЦТ” ХХК-ИЙН ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗАМЫН-ҮҮД СУМЫН НУТАГТ ОРШИХ
“ХАР ОВОО” НЭРТЭЙ БАРИЛГЫН
ЧУЛУУНЫ ИЛ УУРХАЙН” 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: МV-4400031
(2016/001А)

АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 3307905



Агуулга

1	ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	1
1.1	Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр.....	1
1.2	Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл:.....	1
1.2.1	Төслийн нэр.....	1
1.3	Аж ахуйн нэгжийн харъяаллын хаяг:.....	1
1.4	Захирлын нэр, утас:.....	1
1.5	Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг:.....	1
1.6	Тусгай зөвшөөрлийн төрөл.....	1
1.7	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд.....	1
1.7.1	Төсөл хэрэгжих талбайн байршил.....	1
1.8	Урьд оны олборлолтын нийт хэмжээ.....	2
1.9	Нөөцийн тооцоо.....	2
1.10	Ил уурхайн хэсэг.....	3
1.11	Уурхайн хүчин чадал.....	3
1.11.1	Тэсэлгээний ажил.....	4
1.12	Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүд.....	4
1.13	Дэд бүтэц.....	4
1.13.1	Ордын гидрогеологийн нөхцөл.....	4
1.13.2	Усан хангамж.....	4
1.13.3	Цахилгаан хангамж.....	5
2	Замын-Үүд сумын байгаль орчин, Нийгэм эдийн засгийн төлөв байдлын товч таницуулга.....	6
2.1	Төсөл хэрэгжих талбайн физик газарзүйн нөхцөл.....	6
2.1.1	Ландшафтын мужлалаар авч үзвэл.....	6
2.2	Уур амьсгал.....	6
2.3	Геологийн тогтоц.....	6
2.4	Гадаргын усны сүлжээ.....	7
2.5	Гидрогеологийн нөхцөл.....	7
2.6	Хөрсөн бүрхэвч.....	7
2.7	Ургамлан нөмрөг.....	8
2.8	Амьтны аймаг.....	8
3	ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	9
4	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт.....	13
4.1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн төсөв.....	13
5	СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	14

6	НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
6.1	Нөхөн сэргээлтийн зардал	20
7	ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
8	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	25
8.1.1	Дүйцүүлэн хамгаалах газрын байршил	25
8.2	Дүйцүүлэн хамгаалах газрын байршил.....	25
8.2.1	Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээ.....	26
8.2.2	Биологийн олон янз байдлын суурь нөхцөл байдлын үнэлгээ	26
8.2.3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, зорилго, үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв шалгуур үзүүлэлт	27
9	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	28
10	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	28
11	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	28
12	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	28
13	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	27
14	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	29
14.1	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	31

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1-1.	Төсөл хэрэгжих талбайн захын цэгүүд солбилцол	1
Хүснэгт 1-2.	Нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт	2
Хүснэгт 1-3.	Уурхайн ажиллах горим	3
Хүснэгт 3-1.	Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим ба эх үүсвэр... ..	10
Хүснэгт 5-1.	Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, 2024 онд	14
Хүснэгт 6-1	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, 2024 онд	20
Хүснэгт 7-1.	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө.....	21
Хүснэгт 8-1.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	26
Хүснэгт 8-2.	Дүйцүүлэн хамгаалах биологийн олон янз байдлын амьдрах чадварын нийлбэр үнэлгээ	26
Хүснэгт 12-1.	Хог хаягдлаас үүсэх сөрөг нөлөөлөл бууруулах арга	26
Хүснэгт 14-1.	Байгаль орчны Удирдлага зохион байгуулалт	29

1 ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр

“МЦЦТ” ХХК

Регистрийн дугаар: 3307905

Улсын бүртгэлийн дугаар: 611002113

1.2 Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл:

Барилгын материал бутлах үйл ажиллагаа

1.2.1 Төслийн нэр

Дорноговь аймгийн Замын-үүд сумын нутагт орших “Хар овоо барилгын чулууны ил уурхайн” төсөл

1.3 Аж ахуйн нэгжийн харъяаллын хаяг:

Дорноговь аймгийн Замын-Үүд сум, 1-р баг, Сумын төвд-00

1.4 Захирлын нэр, утас:

Захирал: Ч.Туяацэцэг утас 99114757

1.5 Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг:

Байгаль орчны мэргэжилтэн А.Төгөлдөр утас:88991661

1.6 Тусгай зөвшөөрлийн төрөл

Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл

Дугаар: MV-4400031 (2016/001A)

Хүчинтэй хугацаа : 10 жил

1.7 Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол 2022 оны 12-р сард, Монгол улсын Байгаль орчин аялал жуулчлалын яам, Үнэлгээ хийсэн байгууллага. “Үнэт байгаль” ХХК

1.7.1 Төсөл хэрэгжих талбайн байршил

“МЦЦТ” ХХК-ийн Хар-Овоо нэртэй барилгын чулууны орд нь Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутагт говийн бүсийн заагт 26 га талбайг эзлэн оршино. Уг орд нь Улаанбаатар хотоос зүүн урагш 750 км, төмөр замын Замын-Үүд өртөөнөөс баруун урагш 10 км зайд оршино.

Хүснэгт 1-1. Төсөл хэрэгжих талбайн захын цэгүүд солбилцол


#	Уртраг	Өргөрөг
1	43° 45' 47.76"	111° 55' 4.995"
2	43° 45' 47.76"	111° 54' 25.49"
3	43° 45' 56.11"	111° 54' 25.49"
4	43° 45' 56.11"	111° 54' 52.9"
5	43° 45' 0.0"	111° 54' 52.9"
6	43° 45' 0.0"	111° 55' 4.99"

Зураг 1-1. Төслийн ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн талбайн байршил (М1:100000 байрзүйн зураг дээр , L-48-96)

Зураг боловсруулсан: "Үнэт байгаль" ХХК

Төсөл хэрэгжүүлэгч: "МЦЦТ" ХХК

Төслийн хэрэгжих талбай



1.8 Урьд оны олборлолтын нийт хэмжээ

2021 онд ТЭЗҮ-д заасны дагуу 49,000,0 м³ барилгын чулуу олборлосон байна.

1.9 Нөөцийн тооцоо

“Хар-Овоо нэртэй барилгын чулууны ордын талбайд нөөцийн 35 цооног өрөмдөж үүнээс бодитой В зэргийн I, II,III блок, боломжтой С зэргийн I блок байна. Нөөц бодогдсон блокууд нь дунджаар 48.14м, хуулах хөрсний зузаан нь 2.71 м байна. Нөөцийн тооцооны хүснэгтийг доорх хүснэгтэнд үзүүлэв.

Хүснэгт 1-2. Нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт

Нөөцийн блокын дугаар ба нөөцийн зэрэг	Блокын талбай, м ²	Хуулах хөрсний зузаан, м	Ашигт малтмалын зузаан, м	Хуулах хөрсний эзэлхүүн, м ³	Ашигт малтмалын нөөц м ³
В-I	21471.64	2.73	48.26	58617.58	1036221.35
В-II	36793.29	2.72	48.02	100077.75	1766813.79
В-III	28271.38	2.55	48.2	72092.02	1362680.52
Нийт В	86536.31	2.67	48.14	230787.345	4165715.648
С-I	21614.9	2.86	48.13	61818.61	4040325.137
Нийт С	21614.9	2.86	48.13	61818.614	1040325.137
Нийт В+С	108151.21	2.71	48.14	292605.959	5206040.785

1.10 Ил уурхайн хэсэг

“Хар-Овоо” барилгын чулууны ордын бодитой В зэрэглэлээр бодогдсон геологийн нөөц нь 4.16 сая.м³ байна. Ордыг ил аргаар ашиглан, барилгын чулууны тогтоц, хөрсний зузаан, газарзүйн байрлал, чулуулгын шинж чанар зэрэг үзүүлэлтүүдийг харгадлан үзсэний үндсэн дээр уг ил уурхайг авто тээвэртэй ашиглалтын системээр ашиглахаар сонгосон. 2024 онд уурхайн ашиглалт явуулж байсан В-1-ыг үргэлжлүүлж, мөн В-2 блок хуу нэвтэрч ашиглалтын үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн.

Ил уурхайн хэмжээсүүд

Доголын өндөр. Уурхайн жилийн хүчин чадал, бэлэн байгаа экскаваторын утгалтын гүнээс хамааруулж уурхайн доголын өндрийг 5метр байхаар тооцсон.

Доголын хажуугийн өнцөг. Доголын хажуугийн өнцөг нь чулуулгийн шинж чанарын нөхцлөөр 65 градус байна. Энэхүү хэмжээ төсөл зохиомжид мөрдлөг болгодог нөхцөлтэй зөрчилдөхгүй.

Ажлын талбайн өргөн. Уурхайн ажлын талбайн зөвшөөрөгдөх хамгийн бага өргөн нь автосамосвал эргэлт хийх үед 24.66 м байна. Хэвийн ашиглалтын үеийн өргөн нь хөрсөнд 18м, барилгын чулуунд 25.43 м

Ил уурхайн ёроолын өргөн. Уурхайн ёроолын өргөн ажиллаж байгаа техникийн аюулгүй нөхцөлөөр тодорхойлогдоно. Уурхайн ёроолд автосамосвал нь гогцоо хэлбэрийн схемээр эргэлт хийн, экскаватор ачилт хийнэ. Иймд ил уурхайн ёроолын хамгийн бага өргөн (ажлын талбайн хамгийн бага өргөн)24.6 –ээс багагүй байна.

1.11 Уурхайн хүчин чадал

“Хар-Овоо” барилгын чулууны уурхайгаас 2024 онд 49.13 мян.м³ барилгын чулуу олборлон борлуулна. Ил уурхайн сар бүрийн олборлолт харилцан адилгүй байх ба сард хамгийн ихдээ 10.0 мян.м³ барилгын чулуу олборлохоор тусгасан. “Хар-Овоо” нэртэй барилгын чулууны ил уурхайн бэлтгэл ажл жил бүрийн 5-р сараас эхэлж, хөрс хуулалт, барилгын чулуу олборлолтын ажлыг 6-р сараас эхлэхээр төлөвлөсөн бө уурхайн 10-р сарын 31 хүртэл ажиллана.

Ил уурхай нь улирлын чанартай ажиллах бөгөөд хавар 5-р сарын эхнээс 10-р сарын сүүл хүртэл жилд дунджаар 183 хоног, хоногт 8-н цагийн 2 ээлжээр ажиллана. Уурхайн жилийн бодит ажлын хоног 116 байна.

Хүснэгт 1-3. Уурхайн ажиллах горим

#	Горимын үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Утга	Тайлбар
1	Өвлийн улирлын сул зогсолт	хоног	228	11-р сарын 01-ээс 05-р сарын 01 хүртэл
2	Уурхайн жилд ажиллах хоног	хоног	137	05-р сараас 11-р сарын 01 хүртэл

#	Горимын үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Утга	Тайлбар
3	Баяр ёслолын амралт	хоног	5	Хөдөлмөрийн тухай хуулийн 76.1.4, 76.1.5, 76.1.7-р зүйлийн дагуу
4	Цаг агаарын саатал	хоног	7	-
5	Засвар үйлчилгээ	хоног	49	Төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус
6	Жилд ажиллах бодит хоног	хоног	116	-
7	Цаг ашиглалтын коэффициент	хоног	0,83	83%
8	Хоногт ажиллах бодит цаг	цаг	12	Цаг ашиглалт тооцсон
9	Жилд ажиллах бодит цаг	цаг	1160	Цаг ашиглалт тооцсон
10	Уурхайн цагийн хүчин чадал	тн/цаг	8,19	Цаг ашиглалт тооцсон
11	Уурхайн ээлжийн хүчин чадал	тн/ээлж	58,97	Ээлжинд 7,2 цаг ажиллана
12	Уурхайн жилийн хүчин чадал	тн/жил	49000,0	Жилд ажиллах 140 хоног

1.11.1 Тэсэлгээний ажил

“Хар-Овоо”-ийн барилгын чулууны орд нь геологийн тогтоцын хувьд элсэн чулуу ба алевролитаас бүрдэх бөгөөд энэ төрлийн чулуулагийн хатуулаг 4 байх учраас өрөмдлөг тэсэлгээгүйгээр ухаж ачих ажлыг гүйцэтгэнэ.

1.12 Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүд

Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүдэд Doosan 300LCA маркийн экскавтор 1 ш, Hyundai R230LC маркийн экскавтор 1ш, 18м³ тэвшний багтаамжтай Норд бенз автосамосвал 2 ш, Хово автосамосвал 1ш байна. Хөрс хуулалт, барилгын чулуу олборлолтонд экскавторуулын аль аль нь ажиллах боломжтой. Уурхайн тээвэрлэлтэнд БНХАУ-д үйлдвэрлсэн Норд бенз болон Хово маркийн 20 тонн автосамосвалууд ажиллана.

1.13 Дэд бүтэц

1.13.1 Ордын гидрогеологийн нөхцөл

“Хар-Овоо” нэртэй талбайн барилгын чулууны ордын хайгуулын явцад 54 м хүртэл өрөмдөхөд уст давхарга илрээгүй болно. Дайрга чулууны ордын ойролцоох талбайнуудад хийсэн судалгаагаар цоон тооны бага гүний ба гар худаг байдаг. Цаашид гүний худгаас ундны болон технологийн усыг уурхайгаас 0.4 км зайгаас тээвэрлэж хэрэглэнэ.

1.13.2 Усан хангамж

Үйлдвэрт хэрэглэгдэх нийт усны хэрэгцээ нь технологийн ба ундны буюу ахуйн хэрэгцээний зориулалтын уснаас бүрдэнэ. 2011 онд “ Ус ундрага” ХХК-иар ордын талбайд 104м гүнтэй , 5.2 л/с ундрагатай худаг гаргасан байна.

1.13.3 Цахилгаан хангамж

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын “Хар-Овоо” нэртэй ордын ил уурхайн гол цахилгаан хэрэглэгч нь бутлах ангилах хэсэг ба ус зайлуулах шаардлаг гасан үед усны шахуурга орох юм. Цахилгаан хэрэглээгээ Замын-Үүд сумын төвийн эрчим хүчний шугамаас “МЦЦТ” ХХК нь 2015 онд 10кВ-ын станцын өндөр хүчдлийн цахилгаан дамжуулах агаарын шугам 1 км орчим татсан.

2 ЗАМЫН-ҮҮД СУМЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЦУУЛГА

2.1 Төсөл хэрэгжих талбайн физик газарзүйн нөхцөл

Монгол орны физик газарзүйн мужлалаар Өмнөд говийн мужийн зүүн урд үзүүрт Сайншандын өргөн уудам хөндийд залгаа орших Дээрх уулсын муж болон хөндийн газрын гадаргын харьцангуй өндөршлийн зөрүү ихэвчлэн 100-150 м боловч заримдаа 200-250 м хүрдэг. Цөлөрхөг хээрийн бүс, Заримдаг цөлийн бүслүүр гэж хуваана. газрыг хамрах бөгөөд байршлыг доорх зураг болон хүснэгтээр үзүүлж байна

2.1.1 Ландшафтын мужлалаар авч үзвэл

Төв Азийн өндөрлөг тал, хотгор, уулт их муж, Монголын зүүн өмнөд хэсгийн суурьт болон давхаргат өндөрлөг тал, хотгор, сэргэж хэлбэршсэн үлдмэл-цулдам уул, бэлэрхэг уулын муж. Сайншандын хотгор, суурьт болон давхаргат өндөрлөг тал, сэргэж хэлбэршсэн үлдмэл-цулдам уул, бэлэрхэг уул бүхий цөлжүү хээр, заримдаг цөлийн дэд муж. Сайншандын өмнөд хэсгийн заримдаг цөл, хужир мараа болон Эрдэнийн хойд хэсгийн заримдаг цөлийн бүслүүр гэж хуваагдана.

2.2 Уур амьсгал

Дорноговь аймгийн хэсгийн бүс нутгийн уур амьсгал нь манай орны уур амьсгалын эх газарлаг шинж чанарыг бүрэн илэрхийлэх эрс тэс шинжтэй. Өөрөөр хэлбэл сэрүүн бүсийн эх газрын уур амьсгалын эрс тэс эх газарлаг шинж чанарыг илэрхийлсэн тодорхой ялгарсан жилийн дөрвөн улиралтай. Жилийн дундаж температур нь 4.7°C байдаг ба сүүлийн жилүүдэд бүс нутгийн хэмжээнд 1.5°C-аар дулаарсан хандлагатай байна. Хөрсний гадаргын дундаж температур нь ойролцоогоор 5.8°C байдаг байна. Дорноговь аймгийн хэсгийн бүс нутагт жилд дунджаар 85 мм хур тунадас ордог. Хур тунадасны жилийн явцыг авч үзэхэд зуны улиралд 45 мм буюу жилийн нийлбэр хур тунадасны 53 орчим хувь нь унадаг бол үлдсэн хувь нь зунаас бусад улирлуудад унадаг байна.

2.3 Геологийн тогтоц

Судалгааны талбай түүний ойр орчмын геологийн тогтоцыг анх А.Батхүү, А.Б.Бедер нар 1983-1985 онд Дорноговь аймгийн Өргөн сумын нутагт Баргилт овоогийн өргөгдлийн орчимд гүйцэтгэсэн 1:50000 масштабтай эрлийн ажлаар олж тэмдэглэсэн байдаг. Тус ажлаар гипербазитын хэт суурьлаг чулуулагтай гарал үүслийн холбоотой кобальт-никелийн 2 илрэл, 5 эрдэсжсэн цэг олж илрүүлснээс Өмнөд илрэлийг гүнд нь судлах зорилготой нийт 725.5 тууш метр урттай 5 ширхэг цооногийг дунджаар 50м зайтайгаар нэг хайгуулын шугам дээр өрөмдсөн байна. Энэ ажлаар Өмнөдийн илрэлийн никелийн хүдэржилтийг хэтийн төлөвтэй гэж үзжээ.

Энэ дүүрэгт тархсан Өргөн формацын метаморф хурдас дотор өргөргийн дагуу мэшил хэлбэртэй биет үүсгэх доод кембрийн настай хэт суурьлаг интрузив чулуулагтай Өмнөд никелийн орд нь гарал үүслийн холбоотой үүсчээ. Габбро-гипербазитын биетүүд Өргөн формацын кварц-гялтгануурт занарын зузаалагт нийцлэг байдлаар бараг хэвтээ (ойролцоогоор 35°) байрлалтай оршино. Гипербазитуудтай холбоотой никелийн хүдэржилт давхарга (пласт) хэлбэртэй шигтгээлэг хүдрийн биет үүсгэх ба уг биетийн контур интрузив чулуулгийн хүрээтэй давхацдаг

2.4 Гадаргын усны сүлжээ

Төслийн талбайд " Гадаргын усны байнгын урсгалтай сүлжээ байхгүй. Зөвхөн хур бороотой үед уг талбайд байх олон тооны хуурай сайруудаар түр зуурын усны урсгал бий болдог. Төслийн талбайн хойд зүгт 10 км зайд орших уст давхаргатай холбоотой нуур байгааг газрын зургаас харах боломжтой. Энэхүү хэсэг нь ойр орчмын газраас илүүтэйгээр ургамалжсан байгаа нь усны эх үүсвэр байж болохыг харуулж байна. Энэ газарт хамгийн сүүлд хяналт шинжилгээ хийгдсэн нь тодорхойгүй байна. Энэхүү газар нь хөндийн доод хэсэгт байгаа; хуурай гүн жалга нь хуурай нуурын налуу хэсэг; хөндийд хурдас тархсан; хурдасны хуримтлал нь өмнө нь гадаргын ус байгааг харуулсан байна.

2.5 Гидрогеологийн нөхцөл

Гүний ус нь Өмнийн Говийн бүс нутагт хамгийн гол усны эх үүсвэр юм. Энэхүү гүний усны дийлэнх нь чулуужсан ба ус нь маш бага эсвэл бараг нөхөгддөггүй. Цорын ганц сэргэлт нь хязгаарлагдмал хур тунадас бөгөөд энэ нь ердөө 1 мм/жил байна. Уст давхаргад нэг хэвийн дөрөвдөгчийн алювийн элс, бөөн хайрган хурдастай байна. Эдгээр уст давхаргууд голдуу гүехэн бөгөөд (50 м-с бага) ундны ус ба мал услах зориулалтуудаар ашиглагддаг болно. Багаас дунд хэмжээний үр ашигтай мөхлөгт уст давхаргад Дээд Цэрдийн конгломерат, шаварлаг чулуу, элсэн чулуу ба алеврит байна. Гүний усыг голдуу худагнаас, 100 метрийн г.нээс авдаг. Худгийн ундарга нь 0.5 ба 2.0 л/сек-ийн хооронд байна. Уусаагүй хатуу бодисын концентраци нь голдуу 1 г/л-ээс их байна. Пермийн элсэн чулуу, алеврит ба налуу давхарга бүхий хөндлөн конгломератын ундарга нь 0.1 л/сек-ээс 1.0 л/сек-ийн хооронд хэлбэлзэж байна. Уусаагүй хатуу бодисын концентраци нь голдуу 1 г/л-ээс их байна.

2.6 Хөрсөн бүрхэвч

Дорноговь аймгийн Замын Үүд сумын нутаг дахь “МЦЦТ” ХХК-ийн Хар овоо нэртэй барилгын чулууны ил уурхайн ашигт малтмалын талбайн хөрс нь Монгол орны физик газарзүйн мужлалаар авч үзвэл Говийн их мужийн өндрийн бүсшилийн Өмнөгловийн мужийн, Заримдаг цөлийн бор хөрсний Алтанширээгийн 10-р тойрогт хамрагддаг. Судалгааны бүс нутагт Цөлөрхөг хээрийн тэгш талархаг газартай байх ба эдгээр

нутгуудад манай орны говь цөлийн болон хөрсний төлөөллүүд тархдаг онцлогтой. Судалгааны бүс нутгийн хойт хэсгийн нутгийг хамарсан говийн бүсэд цөлөрхөг хээр (говийн)-ийн сайр чулуурхаг бор хөрс, элсэнцэр бор, мараалаг бор хөрсний төрлүүд, төрлүүд дангаар болон бүрдэл байдлаар тархсан байна.

Цөлөрхөг хээрийн мараалаг Бор хөрс. Хотос хонхорууд болон талархаг газруудаар элсэрхэг бор хөрстэй бүрдэл байдлаар, мөн сайруудын хоорондох талархаг гадаргаар тогтворжсон байна. Цөлөрхөг хээрийн Цайварбор хөрс. Энэ хөрс цөлөрхөг хээрийн бор хөрснөөс урагш талархаг газраар голлон тархана. Хөрс үүсгэгч чулуулаг нь делюви-пролювийн сайргархаг элсэнцэр хурдас байх ба гадаргын 70-80% нь янз бүрийн хэмжээтэй сайр чулуугаар бүрхэгдсэн байна.

2.7 Ургамлан нөмрөг

Төслийн талбай нь Монгол орны физик газар зүйн мужлалаар үндсэндээ Төв Азийн өндөрлөгийн Говийн их мужид хамаарна Харин Монгол орны ургамал-газарзүйн мужлалын хувьд (Грубов, 1982) Өмнөд говийн цөлийн (12) тойрогт багтаасан байгалийн үндсэн бүс болох говь цөлийн нутгийн бүрдэл бүхий байгалийн өвөрмөц экосистем юм. Өндөршлийн хувьд 800-1500 м-д хэлбэлзэнэ өмнөд говийн өргөн хөндий, ай сав байрлана. Замын Үүд сумын нутаг бэсрэг уулс гүвээрхэг тал бүхий хээртэй. Жижиг толгод, гүвээ, ухаануудын хоорондох хөндийд хужир мараатай, сийрэг бударганат нам хотос үргэлжилдэг. Үнэгтийн, Хүйсийн, Гялгар зэрэг томоохон говиудтай. Бэсрэг уулсын уулын хүрэн, заримдаа хар хүрэн хөрсөнд дэлгэрсэн хялгана-хазаар өвст, хялгана алаг өвст, сайрын хялгана-хазаар өвст, хазаар өвс-сайрын хялганат, сайрын хялгана-шавагт сайрын хялгана-баглуурт, агь-шаваг-үетэнт, баглуур-сайрын хялгана, хялгана жижиг дэгнүүлт үетэнт, тэгшивтэр хөндийн цайвар хүрэн, бор хөрсөнд ургасан сайрын хялганат, сайрын хялгана-хазаар өвст, сайрын хялгана боролзот, сайрын хялганат-шавагт, сайрын хялганат-баглуурт, сайрын хялганат-бударганат, хазаар өвс-сайрын хялганат, хазаар өвс-таана-жижиг-алаг өвс цөлөрхөг хээрийн бэлчээртэй

2.8 Амьтны аймаг

Төслийн талбайн Монгол орны амьтны аймгийн газарзүйн мужлалаар Төв халхын муж, Хойд говийн тойрогт хамаарна. Бүс нутгаар уулын сул хөгжилт, цайвар хүрэн хөрсөнд дэлгэрсэн хялгана-хазаар өвс-алаг өвст, монгол өвс-баглуурт, агь-элдэв өвст, бүйлс болон бусад сөөг, сөөгөнгөрт бэлчээрт идээшин нутагладаг шивэр алагдаага, хул чичүүл, цагаан зээр, хадны тагтаа, адууч чогчоохой, цоохор хонин гүрвэл, могой гүрвэл зонхилсон өвсөн тэжээлтнийг дагасан саарал чоно, шар үнэг, хярс үнэг ургамлын иж бүрдлийг агуулсан дундаж өндөр, бэсрэг уулс, ухаа толгодот хээрийн говь цөлийн экосистем зонхилно. Төслийн талбайн ойр орчимд нийт 5 багт хамаарах 13 зүйл амьтан тэмдэглэгджээ.

3 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн үйл ажиллагааны улмаас хүрээлэн буй орчинд учрах болзошгүй нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны суурь нөхцөл, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм, эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, судалгаа хийсэн мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн тодорхойлов. Төслийн үйл ажиллагаанаас сөрөг нөлөөлөлд өртөгдөх байгалийн үндсэн тусгагдахуун нь газрын гадарга, агаар, хөрс, ургамал, газрын гүний ус, амьтан юм.

“МЦЦТ”ХХК-ийн Хар овоо нэртэй барилгын чулууны орд төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор шинжээчдийн хэсэг газар дээр нь очиж, төслийн хэрэгжилтийн байдал болон орчны байдалтай танилцаж холбогдох судалгааг хийсэн болно.

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо **магадлан жагсаах** аргыг ашиглаж, үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"-ээр тэмдэглэдэг. Ингэхдээ тухайн нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим зэргийг тодруулах, мөн уг нөлөөлөл байгаль орчин, экологийн тэнцвэрт байдал, орон нутгийн нийгэм-эдийн засагт хэрхэн нөлөөлөх (шууд, шууд бус, эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх, давхардах эсэх) байдлыг үзүүлдэг.

Хүснэгт 3-1. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим ба эх үүсвэр

Байгаль орчны үзүүлэлтүүд	Хэлбэр			Хугацаа		Эргэлт		Эрчим		
	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1.Байгалийн экосистемийн өөрчлөлт										
Газрын доорх урсацын өөрчлөлт										
Гадаргын усны урсацын өөрчлөлт										
Ургамлын бүтцийн өөрчлөлт	x			x			x	x		
Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x		x	x		
Геологийн тогтоцын өөрчлөлт	x				x		x	x		
Зэрлэг амьтдын орон зай			x	x		x				x
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт		x		x		x				x
2.Байгаль орчны чанарын өөрчлөлт										
Газрын доорхи усны чанарын өөрчлөлт		x				x			x	
Гадаргын усны чанарын өөрчлөлт		x		x		x				x
Агаарын бохирдол	x			x			x		x	
Хөрсний бохирдол		x			x	x				x
Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх		x		x		x				x
Дуу чимээ, шуугианы нөлөө	x			x			x			x
3.Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	x				x		x	x		
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x				x		x	x		
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
Археологи, палентологийн олдворт нөлөөлөх										
4.Эдийн засаг, нийгмийн асуудал										
Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	+				+	+			+	
Орон нутгийн орлого нэмэгдэх	+				+	+			+	

Байгаль орчны үзүүлэлтүүд	Хэлбэр			Хугацаа		Эргэлт		Эрчим		
	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
Бүтээн байгуулалтад дэмжлэг болох	+				+		+		+	
Ажлын байр нэмэгдэх	+				+	+			+	
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх		+		+			+			+
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		+		+		+				+
5.Бусад нөлөөлөл										
Уурхайн осол, аваар		х					х		х	
Ахуйн болон үйлдвэрийн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс ба грунтын усыг бохирдуулах.		х		х			х			х
Ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гаргах, шавьж үржих		х		х		х				х
Хүчтэй салхи, үерийн аюул		х		х		х			х	
Дүн	11	11	1	12	9	12	11	5	10	8

Тайлбар: х-болзошгүй сөрөг нөлөөлөл /бөглөгдөөгүй нь тухайн төсөлд хамаарахгүй/

+болзошгүй эерэг нөлөөлөл

Дээрх хүснэгтээс үзэхэд уурхайн үйл ажиллагааны явцад байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл 7, бусад сөрөг нөлөөлөл 6 буюу нийт 13 сөрөг нөлөөлөл, Харин нийгэм эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөлөл 6 болж байна. Үүнээс:

Шууд нөлөөлөл

Байгаль орчин, экологид үзүүлэх болзошгүй нөлөөллийн 7 нь шууд нөлөөлөлд хамаарахаар байна. Эдгээрт уурхайн тээвэрлэлтээс шалтгаалж хөрсний элэгдэл эвдрэл, ургамлын бүтэц өөрчлөгдөх, ахуйн бохир ус, хог хаягдлын цэгийн ариутгалыг муу хийснээс орчин бохирдох, хөрсний бохирдол үүсэх нөхцлийг бүрдүүлж байна.

Мөн уурхайн үйл ажиллагаа нь сумын дэд бүтцийн хөгжил, хүн ам, орлого нэмэгдэх, ядуурлыг бууруулах, ажлын байр бий болоход нэмэр болох сайн талтай юм.

Шууд бус нөлөөлөл

Олборлолтын явцад амьтдаас шавьжны төрөл зүйл дайжих явдал гарах, мөн тээвэрлэлт явуулсанаар агаарт тоосжилт үүсэх, анхаарал болгоомжгүйгээс гал гарах зэрэг нөлөөлөл байж болно.

Богино хугацааны нөлөөлөл

Цаг агаарын хуурайшилтын үед машин механизмын үйл ажиллагааны дүнд тоос агаарт гарах, хүнд механизмын хөдөлгүүрийн дотоод шаталт зэргээр агаарыг богино хугацаанд түр бохирдуулж, ажиллагсадын эрүүл мэндэд муугаар нөлөөлөх, ойр орчмын хөрс, ургамал, талбай тоосонд дарагдаж өөрийн унаган төрхөө алдах, ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, ялаа шавьж үржихэд хүрч болох нь мөн богино хугацааны нөлөөлөлд хамаарна. Иймд салхи ихтэй үед тээвэрлэлтийн ажил хийхгүй байх, тоос шороог багасгах шаардлагатай тохиолдолд усалгаа хийх зэрэг нэмэлт арга хэмжээг авч байх нь зүйтэй. Хог хаягдлын цэгийг тогтсон хугацаанд ариутгаж байх хэрэгтэй.

Урт хугацааны нөлөөлөл

Дээрх хүснэгтээс үзэхэд олборлолтын явцад байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийн 9 нь удаан хугацаагаар нөлөөлөл үзүүлэхээр байна. Үүнд: ургамлын бүтцийн өөрчлөлт, хөрсний элэгдэл, эвдрэл, геологийн тогтцын өөрчлөлт, хөрсний бохирдол зэрэг сөрөг нөлөөллөөс гадна дэд бүтцийн хөгжил, хүн амын болон нутгийн орлого нэмэгдэх зэрэгт буцалтгүй эерэгээр нөлөөлөхөөр харагдаж байна.

Буцаж нөлөөлөх нөлөөлөл

Энэхүү нөлөөлөлд ахуйн хог хаягдлыг ариутгал хийгээгүйгээс хүн амын эрүүл мэндэд эргэж муугаар нөлөөлөх, үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлнө.

Нөлөөллийн эрчим

Болзошгүй нөлөөллийн ихэнх нь сулавтар (8), дунд (7), их (5) зэрэгт хамаарч байна. Харин хөрсний элэгдэл бохирдолд нилээд хүчтэй нөлөөлөхөөр байна. Иймээс хөрсийг хамгаалах асуудал чухал болохыг харуулж байна.

4 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь 2024 оны хугацаанд хэрэгжих бөгөөд уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж, түүнд шаардагдах хөрөнгө зардлыг төлөвлөх үндэслэл болно. “МЦЦТ” ХХК-ийн захиргаа нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг тухайн жилийн үйл ажиллагааныхаа зардалд тусган төлөвлөж, зарцуулалтанд хяналт тавих үүрэгтэй.

4.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн төсөв

2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зарцуулагдах төсвийн нэгдсэн дүнг доорх хүснэгтэд үзүүлэв.

№	Төлөвлөгөө	Төсөв
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, 2024 онд	3,600,000
2.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд	1,866,600
3	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	800,000
4	Хог хаягдлаас үүсэх сөрөг нөлөөлөл	375,000
5.	Байгаль орчны Удирдлага зохион байгуулалт	400,000
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,800,000
7	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	1,500,000
2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт төсөв:		10,341,600

5 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 5-1.Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, 2024 онд

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний								
Барилгын чулуу олборлохоор авсан 26 га талбайн газрын гадарга нөлөөлөлд өртөх	Олборлолт хийх үед хөрсийг эвдрэлээс хамгаалж эвдрэлд өртсөн талбайг засч, байгалийн аясаар нөхөн сэргээх, ургамал ургах нөхцлийг бүрдүүлэх. Олборлолтын үед шаардлагагүйгээр нэмж эвдрэл үүсгэхгүй байх.	26 г талбайн 2 га газарт хөрс хуулалт хийх	төг/ км	-	26	Нөхөн сэргээлтийн хэсэгт тусгагдсан.	2024 онд Үйл ажиллгааны үед	Ургамал хамгааллын тухай хууль. 2-р бүлэг. Ургамал хамгаалах, нөхөн сэргээх. 7.2, 7.5, 7.6-р зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хууль. 31 дүгээр зүйл.
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглалтаас үүдэн газрын хэвлийд мөн хэмжээний хоосон орон зай бий болох	ТТАМ-ын ордыг ашиглах явцад эвдэрсэн газрыг аюул осолгүй болгож, зарим хэсгийн цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулан анх зөвшөөрөл олгосон нутгийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх	Хар-Овоо ил уурхай. ТЭЗҮ-д тооцсон	төг/га	-	26	Нөхөн сэргээлтийн хэсэгт тусгагдсан.	2024онд барилгын ажлын дараа	MNS 5917:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага
Агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах, тоосжилтыг багасгах арга хэмжээ								
Олборлолтын үед жилд 13.8 тн тоосжилт үүсч агаарын чанарт тархана	Олборлолтын дараа ашиглахаа больсон зам, талбайг хааж, нөхөн сэргээх	Төслийн талбайд	Төг/км				2024 онд	Агаарын тухай хууль (Шинэчилсэн найруулга, 2012)
	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилтыг бууруулахын тулд түр замуудыг тогтмол услах /1м ³ газарт 2-4л гэсэн нормын дагуу/	Төслийн талбайд	удаа	50,000	2 га	1,000,000	2024 онд	MNS 4585 :2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
	Барилгын материал тээвэрлэж буй автомашинуудын ачааг тусгай бүтээлгээр бүтээж тоос босохоос сэргийлэх	Ачаа тээвэрлэлтийн бүх автомашинууд	Төг/ма шин	100,000	5	500,000	2024 онд	

“МЦЦТ” ХХК-ийн Дорноговь аймгийн Замын-үүд сумын нутагт орших “Хар овоо” нэртэй барилгын чулууны ил уурхайн” 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
Хар-Овоо нэртэй барилгын чулуу олборлох ил уурхайд ашиглагдаж буй хүнд даацын машин механизмууд, автомашинуудаас хорт хий ялгарч агаарын чанарт нөлөөлөлнө	Ашиглагдаж буй машин техникт засвар үйлчилгээг үйлдвэрлэгчээс өгсөн хугацаанд болон эвдэрсэн үед чанартай хийх	Олборлох ажилд ашиглагдаж буй бүх техник хэрэгслүүд		-			2024 онд	MNS 5885 : 2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага
	Олборлох талбайд ажиллаж буй машин, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг тогтмол хийж, шаардлагагүй үед унтрааж байх	Тусгай зөвшөөрөлт бүхий талбай	-	-	60	Үйл ажиллагааны зардалд багтсан.	2024 онд	Агаарын тухай хууль (Шинэчилсэн найруулга, 2012) MNS 4585 :2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 5885 : 2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага
Тээвэрлэлт болон карьерт ажиллах машин механизм, тээврийн хэрэгслээс дуу чимээ, доргио, чичиргээ үүсэх	Ажилд хэрэглэх машин, тоног төхөөрөмжийг сонгохдоо үндэсний болон олон улсын жишигт нийцэх үзүүлэлттэй эсэхийг сайтар судалж шалгах	Ажилд хэрэглэгдэж буй техник хэрэгслүүд	-	-		Үйл ажиллагааны зардалд багтсан.	2024 онд	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль MNS 4585 :2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
	Машин механизм тоног төхөөрөмжид тогтмол засвар үйлчилгээ хийх		-		Үйл ажиллагааны зардалд багтсан.	2024 онд		
Нийт зардал						1,500,000		
Гадаргын усанд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ								
Тос, тосолгооны материалууд асгарч үерийн усаар угаагдан хуурай сайрын хурдсыг бохирдуулах, улмаар ил задгай устай нийлж гадаргын усыг бохирдуулах	Уурхайн ажлын үед ашиглагдах хүнд машин техник, тээврийн хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдлыг өдөр бүр шалгах, ШТМ алдагдсан тохиолдолд саармагжуулах багаж хэрэгслээр талбайн БО-ны ажилтнуудыг хангах;	уурхайд	Төгрөг	Хөрсөн бүрхэвчийн бууруулах арга хэмжээнд тусгасан			2024 онд	
	Шатах, тослох материалыг стандартын шаардлага хангасан, зориулалтын сав, агуулахад хадгалах, орчинд асгарч	Бүх хэсгүүд		300,000		300,000	2024 онд	

“МЦЦТ” ХХК-ийн Дорноговь аймгийн Замын-үүд сумын нутагт орших “Хар овоо” нэртэй барилгын чулууны ил уурхайн” 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
	алдагдахаас сэргийлэх, алдагдах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж төлөвлөсөн байх;							
	Ил уурхайн олборлох үед ашиглагдах машин техникийн материал болон ахуйн хог хаягдал зэргийг зөвшөөрөгдсөн төвлөрсөн цэгт хаях	Бүх талбайд					2024 онд	
Нийт зардал						300,000		
Газрын доорх усанд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний								
Нийт 650 м ³ Ахуйн хэрэглээний усыг гүний худгаас авч ашигласнаар тухайн орчинд гүний усны нөөц нөлөөлөх	Холбогдох зөвшөөрлүүд ба ус ашиглах дүгнэлтийг сав газрын захиргаанаас авах, усыг ариг гамтай хэрэглэх бодлого хэрэгжүүлэх		төгрөг			200,000	Жил бүр	
Шатах, тослох материал асгарч хөрсөнд шингэн, улмаар бага гүний уст үеүдийг бохирдуулах	Тос шатахуун, бусад аюултай бодисын асгалтыг хянах, гэнэтийн ослын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх, Шатахууны агуулах, машин угаалгын талбайг ойр хавийн уст цэг, ус зайлуулах байгууламжаас дор хаяж 100 м зайд байрлуулах			Хяналтын зардал 200,000		200,000	2024 онд	
	Төслийн үйл ажиллагаанд оролцох машин, тоног төхөөрөмжүүдийн техникийн бүрэн бүтэн байдлыг хангах, засвар үйлчилгээг зохих хугацаанд нь чанартай гүйцэтгэх					Үйл ажиллагааны зардал	2024 онд	Автотээврийн хэрэгслийн хэрэглээний үзүүлэлтүүд. Ангилал, Ерөнхий шаардлага (MNS 4470:2005)
Нийт зардал						400,000		
Хөрсөн бүрхэвчид нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний								
Барилгын чулуу олборлох энэ жилийн үйл ажилаанаас 2 га талбайн үржил шимт хөрс	Олборлох ажил эхлэхийн өмнө шимт хөрсийг стандартын дагуу хуулж, овоолго үүсгэн хадгалах.	шимт хөрс хуулах 2 га талбай	төг/ га			(Үйл ажиллагааны зардалд багтсан)	2024 онд Үйл ажиллаганы ажлын үед	MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт”

“МЦЦТ” ХХК-ийн Дорноговь аймгийн Замын-үүд сумын нутагт орших “Хар овоо” нэртэй барилгын чулууны ил уурхайн” 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
хуулагдан, эвдрэлд өртөх	Хуулсан шимт хөрсийг карьерийн болон эвдэрсэн газрын нөхөн сэргээлтэд ашиглах	Шимт хөрсний овоолго	м ³			(Үйл ажиллагааны зардалд багтсан)	2024 онд Ашиглалтын өмнө	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль /2012 оны 5 сар/
